



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ 2013 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТОВЧ ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2014 он



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2013 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

Монгол Улсын Харилцаа Холбооны Зохицуулах Хороо /цаашид ХХЗХ гэх/-ноос тайлангийн хугацаанд байгууллагын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаа, ХХЗХ-ны Дарга /буюу Төсвийн шууд захирагч/ болон Монгол Улсын Ерөнхий сайд /буюу Төсвийн ерөнхийлөн захирагчтай/ нарын хооронд 2013 онд байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээний зорилт, төлөвлөгөөт болон удирдлагаас өгсөн чиглэл, үүрэг даалгавар, бусад ажлын хүрээнд дараахь арга хэмжээ, төсөл хөтөлбөрийг тус тус хэрэгжүүлэв.

Нэг. Төлөвлөгөөт ажил, арга хэмжээний хүрээнд:

- ❖ ХХЗХ-ны Дарга, Хорооны хуралдаанаас өгсөн удирдамж, чиглэл, хуралдааны дэгийн дагуу Хорооны ээлжит хуралдааныг сард 1-ээс доошгүй удаа зохион байгуулж, тайлант хугацаанд нийтдээ 15 удаагийн хуралдаанаар төлөвлөгөөт болон цаг үеийн асуудлуудыг хэлэлцэн тогтоол, тэмдэглэл гарган шийдвэрлэсэн болно. ХХЗХ-ны 14 удаагийн ээлжит, 1 удаагийн ээлжит бус хуралдаанаар зохицуулалтын чиглэл, дүрэм журам, нөхцөл шаардлага, радио давтамжийн хуваарилалт, төлөвлөлтөнд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчилэх, тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, цуцлах, сэргээх зэрэг хэлэлцсэн асуудлаар нийтдээ 73 тогтоол, 21 тэмдэглэлийг тус тус гаргуулан шийдвэрлэж, тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавин ажиллав. Тус хорооны хуралдаанаар зохицуулалтын баримт бичиг нөхцөл шаардлагын шинэчлэлтийг хийх явцад одоо мөрдөж байгаа 70 гаруй баримт бичгийн 50 гаруйг шинэчилэх, нэмэлт өөрчлөлт оруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэв /Хавсралт-1/.
- ❖ “ХХЗХ-ны Дарга /Төсвийн шууд захирагч/ болон Ерөнхий сайд /Төсвийн ерөнхийлөн захирагч/-ын хооронд байгуулсан 2012 оны бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээний биелэлт”-ийг Төрийн албаны зөвлөлийн 2008 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин, төрийн үйлчилгээний албан хаагчийн үр дүнгийн гэрээг үнэлж, дүгнэх журам”-ын 2 дугаар хавсралтын дагуу бэлтгэж, 2013 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 01/30 албан тоотор ЗГХЭГ-т хүргүүлэв.
- ❖ Монгол Улсын Ерөнхий сайд болон ХХЗХ-ны Дарга нарын хооронд 2013 онд байгуулах үйл ажиллагаа, бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ, ХХЗХ-ны санхүүгийн төсвийн төслийг тус тус боловсруулан 2013 оны 1 дүгээр сард ЗГХЭГ-т хүргүүлэв. Монгол Улсын Ерөнхий сайдаас 2013 онд байгуулах үйл ажиллагаа, бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ, төсвийн хамт 2013 оны 1 дүгээр сарын 15-ний өдөр баталгаажуулсан ба хэрэгжилтийг зохион байгуулж, тайлант хугацаанд гүйцэтгэлийг гаргаж, ЗГХЭГ-т тайлагнаж хүргүүлсэн болно.
- ❖ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.8 дахь хэсэгт заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороо, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2013 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 18/09 тоот хамтарсан тогтоолоор “Радио,

- телевизээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх журам"-ыг батлан гаргаж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллав.
- ❖ ЗГХЭГ-аас өгсөн чиглэл, удирдамжийн хүрээнд тус хороо нь “МХХТ-ийн салбарын 7 тэргүүлэх стратеги” танилцуулах арга хэмжээ, “Салбарын стандартчиллын Улсын тооллого”, “Өглөөний шинэ санаа” арга хэмжээг зохион байгуулах, техник хэрэгслийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэн хамтран ажиллав.
 - ❖ Монгол Улсын Засгийн газрын батлан хэрэгжүүлж буй “Өргөн зурвасын сүлжээ”, “Өрх бүрт шуудан”, “Радио телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх”, “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах”, “Үндэсний хиймэл дагуул” зэрэг Үндэсний хөтөлбөрийн холбогдох зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хагас жил, жилийн байдлаар нэгтгэн ЗГХЭГ-т хүргүүлэн тайлагнаж ажилласан бөгөөд радио телевизийн нэвтрүүлгийг тоон системээр дамжуулах бодлого, хөтөлбөрийн хүрээнд хэрэглэгчид өгөх зөвлөмжийг асуулт, хариулт хэлбэрээр болон нийтлэл хэлбэрээр бэлтгэн цахим хуудсаар мэдээлэв.
 - ❖ Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны салбарын эрх зүйн орчинг улам боловсронгуй болгох, ялангуяа Радио долгионы тухай хууль /1999 он/, Харилцаа холбооны тухай хууль /2001 он/, Шуудангийн хууль эрх зүйн акт баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах, Радио өргөн нэвтрүүлгийн хууль-ийн төсөл шинээр боловсруулах ажлын хэсгийг МТШХХГ, ХХЗХ-ны Дарга нарын 2013 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 237 тоот хамтарсан тушаалаар байгуулан ажилласан.
 - ❖ Гэмт хэргийн тухай хууль, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Инновацийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал мэдээлэл авах эрхийн тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Концессийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Мэдээллийн аюулгүй байдлын тухай хууль, Цахим засгийн тухай хууль, Кибер гэмт хэргийн тухай хууль, Цахим гүйлгээ, төлбөр тооцооны тухай хууль, Цахим хэлцлийн тухай хууль, Өгөгдөл хамгаалах тухай хууль зэргийн төслийн боловсруулахад ХХЗХ-ны төлөөлөл ажлын хэсэгт оролцож, хорооны зүгээс холбогдох саналыг ЗГХЭГ, ХЗЯ, МТШХХГ-т тус тус хүргүүлэв.
 - ❖ Мэргэжлийн хяналтын эрх, үүрэг салбар салбарт нь шилжиж байгаатай холбоотой харилцаа холбооны тухай хууль болон бусад хуульд орох нэмэлт, өөрчлөлтийн төслийг холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран 2013 оны 4 дүгээр сард ЗГХЭГ-т хүргүүлсэн.
 - ❖ Хаягжуулалтын хуулийн төслийг боловсруулах ажлын хүрээнд хуулийн төслийн шинэчилсэн хувилбарыг боловсруулан ГХГЗЗТ-т хүргүүлсэн бөгөөд Монгол Улсын Хаягжуулалтын хуулийн дагуу боловсруулагдаж байгаа хаягжуулалтын багц стандарт, журмын төсөл дээр ажиллаж саналаа холбогдох байгууллагуудад хүргүүлэн хамтран ажиллав.
 - ❖ ГЕГ-тай хамтран Гаалийн тухай, Гаалийн тарифын тухай, Гаалийн татварын тухай хуулиудад болон Улс хоорондын шуудангийн илгээмжийг гаалийн хилээр нэвтрүүлэх журамд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэгт ХХЗХ-ны төлөөлөл оролцон ажиллаж, улс хоорондын шуудангийн илгээмжийн татвар авахтай холбоотой заалтыг Дэлхийн шуудан холбооны конвенци болон бусад орнуудын жишиг заалт дээр үндэслэн хөдөлмөрийн доод хэмжээг 3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний үнэ бүхий эд зүйл агуулсан шуудангийн илгээмжийг татваргүй нэвтрүүлэх заалтыг оруулахаар ХХЗХ-ноос санал боловсруулан ХЗЯ-д хүргүүлсэн болно.
 - ❖ Үндэсний аюулгүй байдал, түүх, хэл соёл, ёс заншлыг сурталчлан соёл иргэншлийн аюулгүй байдлыг хамгаалах, эх орон, үндэс угсаа, ололт дэвшлээрээ бахархах, үндэсний ашиг сонирхолыг дээдлэх нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэхэд өргөн нэвтрүүлгийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх талаар Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн шинжээч нартай хамтарсан уулзалтыг 2013 оны 3 сард зохион байгуулж, хамтран ажиллах чиглэлээр

санал солилцов. Телевиз, кабелийн сувгуудаар гарч байгаа чат, урсдаг зар нь Монгол хэл соёлыг гажуудуулж, хүүхэд залуучуудад Монгол хэлний бичгийн болон ярианы зөв хэвшил бүрэлдэн тогтоход, улмаар Монгол хэл соёлоо алдах сөрөг үр дагавар авчирч байсныг харгалзан үзээд “Бүх төрлийн чат, мессеж, урсдаг зарыг дэлгэцээр гаргахгүй байх, тусгайлан гаргасан зарын цагаар явуулах. Урсдаг зарыг латин бус кирилл үсгээр, үг үсгийн алдаагүй зөв бичих”-ийг Зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлагад тусган шинэчилж, бүх телевиз, кабелийн сувгуудад мөрдүүлэн хэрэгжилтэнд хяналт тавин ажиллав.

- ❖ Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам батлагдсаны дагуу Гадаадын хөрөнгө оруулалттай тусгай зөвшөөрөл эзэмшигчийн болон нийт тусгай зөвшөөрлийн мэдээлэл, стандартын үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл болон өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын мэдээлэл, саналыг боловсруулж, тус зөвлөлд албан тоотоор хүргүүлэв.
- ❖ Тайлангийн хугацаанд буюу 2013 онд нийтдээ харилцаа холбооны үйлчилгээ, шуудангийн ашиглалт үйлчилгээ, тусгай дугаар, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл болон радио давтамжийн тусгай зөвшөөрөл, давтамж ашиглах эрхийн бичиг авах, сунгах, нэмэлт өөрчлөлт оруулах, цуцлах талаар хүсэлт ирүүлсэн 290 гаруй иргэн, хуулийн этгээдээс материалыг хүлээн авч, Монгол Улсын “Харилцаа холбооны тухай” хууль, “Радио долгионы тухай” хууль, “Шуудангийн тухай”, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”, холбогдох хууль, тогтоомж, дүрэм журмын хүрээнд үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, техник, технологийн судалгаа, давтамжийн нөөц, сүлжээ төлөвлөлтийн хуваарь, эдийн засгийн чадавхи, үр дүнгийн үнэлгээг хийж, шаардлагатай үед газар дээр нь танилцах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, зөвшөөрөл болон бүртгэлийн гэрчилгээ олгох, сунгах, нэмэлт өөрчлөлт оруулах, цуцлах талаар холбогдох шийдвэрийг гаргаж ажиллав. ХХЗХ-ноос Монгол Улсын Ерөнхий Сайдын захирамжийн дагуу байгуулсан аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тогтолцоог шинэчилэх, боловсронгуй болгох арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх ажлын хэсгийн удирдамжийг хэрэгжүүлэх, МТШХХГ-аас албан тоотоор ирүүлсэн зөвлөмж чиглэлтэй холбогдуулан сүлжээ, үйлчилгээ, радио давтамжийн тусгай зөвшөөрлийг 2013 оны 8 дугаар сар хүртэл хугацаагаар түр олгоогүй болно.
- ❖ ХХЗХ-ны 2013 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 37 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ыг иргэд, аж ахуйн нэгж, компани, байгууллагуудад танилцуулах, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулж, 2013 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс тусгай зөвшөөрөл олгох ажлыг эхлүүлсэн. ХХЗХ-ны 2013 оны ээлжит 5 удаагийн хуралдаанаас Монгол Улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.1, 14.1.1, Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.2, 15.1.1, тус хорооны Дүрмийн 3 дугаар зүйлийн 2.2 дахь хэсгийг үндэслэн тусгай зөвшөөрөл шинээр олгох, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох шийдвэрийг гарган хэрэгжүүлж ажиллав. Харилцаа холбооны үйлчилгээ, шуудангийн ашиглалт үйлчилгээ, тусгай дугаар, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл болон радио давтамжийн тусгай зөвшөөрөл, давтамж ашиглах эрхийн бичиг авахаар ирүүлсэн материал, хүсэлтийг судлан дүгнэлт гаргаж, ХХЗХ-ны хуралдааны шийдвэрээр нийтдээ 57 хуулийн этгээдэд сүлжээ, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл, 30 хуулийн этгээдэд радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл шинээр олгох, 12 тусгай зөвшөөрлийн хамрах хүрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, 15 тусгай зөвшөөрлийг сэргээх, 38 түдгэлзүүлэх, 66 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг шийдвэрлэсэн болно. Түүнчлэн телевизийн олон сувгийг олон цэгт дамжуулах утасгүй систем (MMDS, MUDS), телевизийн өргөн нэвтрүүлэг, хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэг, өргөн зурвасын өндөр хурдны интернэт, радио релей, сансрын хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд ашиглах радио давтамжийн тусгай зөвшөөрлийг 30 аж ауйн нэгж, хуулийн

этгээдэд Хорооны хуралдааны шийдвэрээр олгох арга хэмжээг авч ажиллав. Тусгай зөвшөөрөл олгох, нэмэлт, өөрчлөлт оруулах тогтоол гарснаас хойш ажлын 30 хоногийн дотор тусгай зөвшөөрлийн гэрээг байгуулаагүй, төлбөр төлөөгүй тохиолдолд “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-ын 5.9 заалтын дагуу тусгай зөвшөөрлийг хүчингүйд тооцохоор 2013 оны 37 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам”-д зохицуулалтын орчинг өөрчлөн тусгаж боловсронгуй болголоо. Хорооны хуралдааны тогтоол, тэмдэглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах, хуралдааны шийдвэрийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид, иргэд, байгууллагуудад албажуулан нийтдээ 180 гаруй албан тоотоор хүргүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэв.

- ❖ Салбарын хэмжээнд мөрдөж байгаа тусгай зөвшөөрөл, давтамжийн эрхийн бичиг сунгах асуудлыг боловсруулан холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу байгууллага аж ахуйн нэгжийн радио давтамж ашиглах эрхийн бичгээ сунгуулах, нэр шилжүүлэх, давтамж, станцын тоонд өөрчлөлт оруулах талаар гаргасан хүсэлтийг ирүүлсэн баримт бичиг, газар дээр нь шалгасан шалгалтын дүнг үндэслэн тухай бүрт дүгнэлт гаргаж, ХХЗХ-ны Даргын тушаалаар шийдвэрлэж сунгалтыг хийсэн болно. Тайлант хугацаанд хугацаа сунгагдсан нийтдээ 400 тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийн 53 нь радиогийн тусгай зөвшөөрөл, үйлчилгээний 149, эрхийн бичгийн 181 зөвшөөрөл тус тус байна. Тусгай зөвшөөрлийг сунгах асуудлыг шинэ журмын дагуу холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран шийдвэрлүүлж гэрээг сунгах тухай бүр холбогдох тооцоог гаргаж, хянан ажилласан болно. ХХЗХ-ны хуралдаанаас Улаанбаатар хотод тусгай зөвшөөрөл авсан бөгөөд үйл ажиллагаа эхлээгүй, кабелийн сувгийн үйлчилгээ эрхлэгчдэд хийсэн 5 газрын хамтарсан үзлэг шалгалтанд хамрагдаагүй нийт 45 кабелийн сувгийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан талаар мэдэгдэл хүргүүлж ажлын тайлан, зөрчлөө арилгасан тухай тайлан мэдээлэл, нотолгоо баримтыг авч шалгаж, тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах шийдвэр гаргалаа.
- ❖ Шуудангийн үйлчилгээ үзүүлэх Б ангилалын тусгай зөвшөөрлийн дагуу үйлчилгээ үзүүлэгч 11 аж ахуйн нэгжид хугацаа дуусч байгаа талаар мэдэгдэл хүргүүлсэн бөгөөд холбогдох материалаа ирүүлсэн 8 үйлчилгээ үзүүлэгчийн гэрээний болон нөхцөл, шаардлагын биелэлтэнд дүгнэлт гаргасны дагуу сунгах хүсэлтийг хүлээн авч холбогдох шийдвэрийг гаргуулав.
- ❖ ХХЗХ-ны 2013 оны ээлжит хуралдаанаар Монгол Улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай 14.1.1, 14.1.4 заалтууд болон Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.2, 15.1.1, 15.1.3 дах заалт болон Радио долгионы тухай хуулийн 20.5.3, радио долгион ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг олгох, сунгах, хүчингүй болгох, биелэлтэнд нь хяналт тавих журмын 6.1 буюу үйлчилгээний тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхэлсэн зэргийг тус тус үндэслэн үйл ажиллагаагаа хэвийн жигд явуулаагүй, өөрөө хүсэлт гаргасан, тусгай зөвшөөрлийн гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй зэрэг үндэслэлээр хуулийн этгээдийн 72 мэдээлэл, харилцаа холбоо, шуудангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл, 24 радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл, 93 радио давтамжийн эрхийн бичиг, нийтдээ 187 хуулийн этгээд, аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээг авч шийдэрлүүлэв.
- ❖ Монгол Улсын Ерөнхий Сайдын 2013 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 143 тоот захирамжаар байгуулагдсан өргөн нэвтрүүлгийн чиглэлээр ажиллах ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгээс Ази, номхон далайн орнуудын Өргөн нэвтрүүлгийн (АВУ) байгууллагын 3 зөвлөхтэй хамтран 2013 оны 12 дугаар сарын 7-17-ны өдрүүдэд ЗГХЭГ, МТШХХГ, ХХЗХ зэрэг холбогдох байгууллага, салбарын судлаач, мэргэжилтнүүд, үйлчилгээ эрхлэгчид, иргэний нийгмийн төлөөлөл оролцсон өргөн нэвтрүүлгийн салбарын хөгжлийн бодлого, чиглэл, хууль эрх зүйн орчны шинэчлэлт, зохицуулалтын арга хэмжээний санал, хувилбарын талаар хэлэлцүүлэг зохион байгуулав.

- ❖ “Монгол Улсын радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн системийг тоон технологид шилжүүлэх” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор тоон радиогийн зохицуулалтын чиглэл, техникийн шийдэл боловсруулах ажлын хэсгийн хүрээнд Тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн судалгаа, үйл ажиллагааны чиглэлүүд, оролцогчдын эдийн засаг санхүүгийн чадварын судалгааг хийж, 21 аймаг 375 сумдын радио давтамж, ашиглалтын судалгааг гаргаж, холбогдох байгууллагад тайлагнаж ажиллав.
- ❖ Монгол Улсын Засгийн Газрын 2013 оны 01 тоот тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Цахим хуудас дахь сэтгэгдлийн нэгдсэн систем”-ийг нэвтрүүлэх арга хэмжээг холбогдох газар, байгууллага, ТББ-тай хамтран боловсруулж, 2013 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн баталж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллав.
- ❖ Засгийн газрын 2013 оны 06 тоот тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ХХЗХ-ны 2013 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн 26 тоот тогтоолоор “Монгол Улсын мэдээлэл, холбооны сүлжээний зохицуулалт”-ыг баталсан бөгөөд энэ баримт бичигт сүлжээний үйлчилгээ эрхлэгч мэдээлэл, холбооны үндсэн сүлжээ барьж байгуулах тухай бүрдээ ХХЗХ-д хүсэлт, шинээр байгуулах сүлжээний төлөвлөлт, үндэслэл, зорилгыг ирүүлэн сүлжээ байгуулах зөвшөөрөл авах тухай зохицуулалтыг тусгасан. Энэхүү зохицуулалтын хүрээнд одоогийн үүсээд буй сүлжээний давхардлын, төрийн өмчийн сүлжээний үнэгүйдлийн талаар асуудлуудыг тодорхой хяналттай болгон мэдээлэл, харилцаа холбооны салбарт төрөөс баримтлах бодлогыг баримтлан хэрэгжүүлэх эрх зүйн боломжтой болоод байна.
- ❖ ҮАБЗ-ийн зөвлөмж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын дагуу хүрээнд холбогдох тоног төхөөрөмжүүдийг худалдан авах тоног төхөөрөмжүүдийн дүгнэлт гаргаж, угсралт суурилуулалтанд холбогдох байгууллагатай хяналт тавьж, ашиглалтанд хүлээлгэн өгч ажилласан.
- ❖ Засгийн газрын 2013 оны 411 тоот тогтоолоор батлагдсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам”-ыг хэрэгжүүлэх зорилгоор байгууллагын мэдээллийн ил тод байдлыг илэрхийлсэн мэдээллүүдийг байгууллагын цахим хуудсанд байршуулаад байна.
- ❖ Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 137 тоот тогтоолоор батлагдсан “Үндэсний хиймэл дагуул” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулагдсан үндэсний тандан судалгааны хиймэл дагуул хөөргөх судалгаа, хурал, семинарууд болон олон улсын цахилгаан холбооны байгууллагад хиймэл дагуулын давтамжаа бүртгүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд МТШШХГ-тай хамтран ажиллав.
- ❖ ХХЗХ-ноос санаачлан МШТХХГ-тай хамтран ажилласнаар тус хорооны төлөөлөгчид ОХУ-ын Холбооны яамтай хоёр орны хилийн бүсэд ашиглах радио давтамжийн зурвасуудын нийт 7 гэрээ мөн 1983 онд байгуулсан гэрээний төслүүд дээр хамтран ажиллаж саналаа солилцсон, тус гэрээтэй холбоотой оператор компануудын төлөөлөлүүд, Хил хамгаалах ерөнхий газрын Холбоо мэдээлэл технологийн хэлтэс, Гадаад харилцааны яамны холбогдох хүмүүстэй уулзалт зохион байгуулж санал авч гэрээнд тусгалаа. ХХЗХ-ны төлөөлөгчид 2013 оны 4 дүгээр сарын 15-19-ны өдрүүдэд ажиллаж, ОХУ-ын Москва хотод тус улсын Харилцаа Холбооны яамтай хоёр орны хилийн бүсэд ашиглах радио давтамжийн зурвасуудын нийт 6 гэрээг (Радио, ТВ-1, үүрэн холбооны-5) эцэслэн гэрээний төслүүд дээр 2 тал гарын үсэг зурж баталгаажуулав. Эдгээр хоёр талын гэрээний төслүүдийг 2013 оны 8 дугаар сард Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжсэн болно.
- ❖ Шуудангийн албанаас боловсруулан Монгол Улсын Ерөнхий сайдын 2013 оны 24 дүгээр захирамжаар давуу эрхийн бүсийг шинэчилэн тогтоох арга хэмжээг авлаа.
- ❖ Засгийн газраар батлуулах тоон телевизтэй холбоотой Set top box –ийн журам, Төлбөр тооцооны үндэсний төвөөс ирүүлсэн “Хөдөлгөөнт банкны тухай журам”-д холбогдох саналыг хүргүүлж, нөлөөллийн шинжилгээ хийж, ЗГХЭГ-т хүргүүлэв.

- ❖ "Мэдээллийн аюулгүй байдлыг хангах" үндэсний хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 5 тоот тогтоолыг хэрэгжүүлэх, холбогдох арга хэмжээ, мэргэжил арга зүйн зөвлөгөө боловсруулах, төрийн байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлын төвшинг тогтоох үнэлгээ хийх ХХЗХ, ТЕГ-ийн КАБГ, МТШХХГ төлөөлөл оролцуулан хамтарсан ажлын хэсгийг 2013 оны 8 сард байгуулж ажиллав. Ажлын төрийн байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлын төвшинг тогтоох, эрсдэлийн үнэлгээ хийхэд шаардагдах тоног төхөөрөмжүүдийн үзүүлэлт болон үнийн судалгааг хийлээ.
- ❖ Төрийн байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсэгтэй хамтран ажиллаж, судалгааны тайлан гаргах ажлын хүрээнд нийт 22 яам, агентлагт шалгалт хийж, Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийж, тайлан дүгнэлт холбогдох зөвлөмжийг боловсруулан гаргасан.
- ❖ Улсын төсвийн хөрөнгөөр 2012, 2013 онд суурилагдсан тоон телевизийн нийт 86 сайт, тоног төхөөрөмжийн суурилуулалтын ажлын гүйцэтгэлийн шалгалт хийж, суурилагдсан тоон телевизийн төхөөрөмжийн ажиллагааны чанар байдал, нэвтрүүлэгчийн хамрах хүрээний хэмжилтийг хийж гүйцэтгэн түүний дагуу дүгнэлт гаргасан.
- ❖ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нэр бүхий 38 сум, суурин газарт суурилуулагдах тоон нэвтрүүлэгчийн хамрах хүрээ, байршилын сонголтыг олон улсын хэмжээнд ашиглагддаг программ хангамжийг ашиглан нарийвчилсан тооцоо, судалгаа хийж баталгаажуулах ажлыг зохион байгуулж, МТШХХГазарт албажуулж хүргүүлсэн.
- ❖ Өрх бүрт шуудан төслийн хүрээнд улсын төсөв, БНҮУСангаас МШ ТӨХК-д 2012 онд хэрэгжүүлсэн 2,9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын өгөөжгүй гэсэн дүгнэлтийг гаргаж, төслүүдийг шинэчлэн боловсрууллаа. Ерөнхий сайдад шинэчилсэн төслийг танилцуулснаар зарим төслүүдийг Ерөнхий сайдын байгцаас санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлүүлсэн бөгөөд уг төслүүд 2013 онд бүрэн хэрэгжсэн болно.
- ❖ Телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 4 дэд ажлын хэсгийг зохион байгуулж, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэхтэй холбоотой сүлжээ төлөвлөлт, талхалтын судалгаа, хөрөнгө оруулалт болон өрхийн судалгааг нарийвчлан боловсруулав. Үндэсний хөтөлбөрийн нэг хэсэг болох радиогийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэхтэй холбогдуулан үндсэн суурь судалгааны ажлыг зохион байгуулж, тайлан мэдээллийг Зохицуулах хорооны цахим хуудсанд байршуулж, МТШХХГ болон бусад байгууллагуудад хүргүүлэв.
- ❖ Харилцаа холбооны тухай хуулийн 8.9 дүгээр зүйлийн дагуу Зохицуулах хорооноос орон нутагт төлөөлөгч ажиллуулах журам, гэрээний төслийг шинээр боловсруулан Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Хорооны Даргын 2013 оны 39 дүгээр тушаалаар батлуулсан болно. Энэхүү журмын дагуу орон нутгийн төлөөлөгчийн сонгон шалгаруулалтыг байгууллагын вэбсайтаар зарлаж, 9 аймагт орон нутгийн төлөөлөгчдийг томилон. Тухайлбал, Хөвсгөл, Мөрөн, Увс, Улаангом, Ховд Жаргалант, Өмнөговь аймгийн 4 төлөөлөгчдийн гэрээг сунгаж, Баян-өлгий, Өлгий, Өвөрхангай, Арвайхээр, Сэлэнгэ, Сүхбаатар, Хэнтий, Хэрлэн аймгийн 4 орон нутаг дахь хорооны төлөөлөгчдийг Хорооны Даргын 2013 оны 295 тоот тушаалаар томилон. Орон нутагт хорооны орон тооны бус төлөөлөгчтэй болсноор зохицуулалтын үйл ажиллагааг орон нутагт сурталчилах, тусгай зөвшөөрлийн үйлчилгээг хөдөөд орон нутагт шуурхай хүргэх, зөрчил дутагдлыг газар дээр нь тооцох, арилгуулах боломж бүрдүүлэв.
- ❖ Мэдээлэл, харилцаа холбооны салбарын Экспо-2013 үзэсгэлэн болон бусад хурал, семинарыг 2013 оны 5 сарын 19-27-ны өдрүүдэд МТШХХГ, салбарын байгууллага, ААН, компаниудтай хамтран зохион байгуулсан ба хурал, семинарыг албан ёсны хамтран зохион байгуулагчаар оролцлоо.
- ❖ Стандартчилал хэмжил зүйн газрын удирдлага, холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулж, баталгаажуулалтын үндсэн бичиг баримт Чанарын гарын авлага

- холбогдох баримт бичгийг боловсруулахад шаардагдах дүрэм, журам стандартын талаар зөвлөгөө авч ажиллав. Баталгаажилтын үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын чанарын гарын авлага, ном товхимол холбогдох материалын талаар дэлгэрэнгүй судалгаа хийсэн болно. ХХЗХ-ны Даргын 2013 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 93 дугаар тушаалаар Харилцаа холбооны тоног төхөөрөмжийн баталгаажуулалтын өргөдөл хүсэлт хүлээж авахаас тохирлын үнэлгээний гэрчилгээ олгох хүртэлх процесс, эдгээр үйл ажиллагаатай холбоотой дүрэм журмыг боловсруулах ажлын хэсэг байгуулан дараах баримт бичгийг боловсруулан Хорооны хуралдааны 2013 оны 27 дугаар тогтоолын хаьсралтаар тус тус батлуулан хэрэгжилтийг зохион байгуулах бэлтгэлийг хангаад байна.
- ❖ Хорооны хуралдааны 2013 оны 49 тоот тогтоолоор "Интернэтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тусгай нөхцөл шаардлага"-ыг боловсруулан батлуулав. Интернетийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд Монгол Улсын хууль тогтоомж, тусгай зөвшөөрлийн гэрээний нөхцөл шаардлагын хэрэгжилтийн талаар шалгалт хийж зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчлийг арилгах, таслан зогсоох, шударга өрсөлдөөнийг дэмжих зорилгоор Улаанбаатар хотод интернетийн үйлчилгээ үзүүлж буй нийт 34 үйлчилгээ эрхлэгчийн үйлчилгээний чанар, үнэ тариф, зах зээлийн эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын талаар нэгдсэн судалгааг хийж, Хорооны хуралдаанд хэлэлцүүлэн шийдвэрлүүлж үр дүнд нь тусгай зөвшөөрлийн зохицуулалтын баримт бичгийн хүрээнд 15 үйлчилгээ эрхлэгчдэд холбогдох шаардлагыг хүргүүлсэн бөгөөд дахин шалгалтыг хийсэн эдгээр ажлын хүрээнд үнэ тариф тогтоох үндэслэл буюу чанаргүй үйлчилгээг бий болоод байсан 4:1 зарчим мөн хэрэглэгчийн хурд хэмжих хэсэг цаашид хийгдэх зохицуулалтад шаардагдах мэдээллийн эх үүсвэрийг бүрдүүлэх чиглэлээр холбогдох саналыг боловсруулав.
 - ❖ Тус хорооноос "Тусгай дугаар ашигласан ярианы үйлчилгээний зохицуулалт"-ын баримт бичгийн төсөл, хэрэгжүүлэх үе шатны төлөвлөгөөг тус тус боловсруулж, цахилгаан холбооны үйлчилгээ эрхлэгчид болон тусгай дугаар эзэмшигчдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулсан. цахилгаан холбооны үйлчилгээ эрхлэгчид болон тусгай дугаар эзэмшигчдийн саналыг тусган Хорооны 2013 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 60 тоот тогтоолоор батлуулсан болно.
 - ❖ Оюуны өмчийн газар, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар, Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллаж, хууль тогтоомжийг зөрчсөн цахим хуудсуудыг тэдгээр байгууллагын дүгнэлтийг харгалзан www.blacklist.mn сайтад бүртгэж, Монгол Улсаас хандалтыг хязгаарлах зохицуулалтыг хийж байна. Энэ цахим хуудсанд одоогоор оюуны өмчийн болон бусад холбогдох хууль зөрчсөн зарим цахим хуудсыг бүртгэн, хаах арга хэмжээ аваад байна.
 - ❖ ХХЗХ-той байгуулсан гэрээний үндсэн дээр Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа 44 кабелийн сувгийн үйлчилгээ эрхлэгчдийн эфирт нийт 6 үзүүлэлтээр Максима ХХК-иар байнгын мониторинг хийлгэж, улирал бүр тайланг нэгтгэн авч үнэлгээ, дүн шинжилгээ хийдэг болно. Тус хорооноос хийж буй мониторингийн улирал бүрийн тайланг байгууллагын цахим хуудсанд байршуулан үнэлгээ өгч ажиллаж байна.
 - ❖ ХХЗХ-ны 2011 оны 44 тоот тогтоолоор баталсан "Үндэсний радио давтамжийн төлөвлөлтийн хүснэгт"-д Дэлхийн радиогийн 2012 оны их хурлаар орсон нэмэлт, өөрчлөлтүүдийг тусган Мэдээллийн технологи, шуудан харилцаа холбооны газрын Даргын 2013 оны 37 тоот тушаалаар "Үндэсний радио давтамжийн үндэсний төлөвлөлт"-ийг шинэчилэн батлуулсан. Тус хорооноос "Үндэсний радио давтамжийн үндэсний төлөвлөлт"-ийг хэрэгжүүлэх, хуваарилалт, зохицуулалтын арга хэмжээг авч ажиллав.
 - ❖ ХХЗХ-ноос хиймэл дагуулаар дамжуулах телевизийн өргөн нэвтрүүлгийн нэг сувгийн дамжуулах хурд, нийт зурвасын өргөнд тавих шаардлагыг боловсруулж, 2013 оны 12 тоот тогтоолоор DVB-T технологиор телевизийн өргөн нэвтрүүлэг дамжуулахад шаардах

- нэг ТВ сувгийн урсгал нь стандарт нягтралтай (SD) бол 3-6 Мбит/сек, өндөр нягтралтай бол (HD) 8-16 Мбит/сек байх, DVB-T2 технологээр SD -1.5 - 4 Мбит/сек, өндөр нягтралтай бол (HD) 4-8 Мбит/сек байх урсгалын доод, дээд хязгаарыг баталсан болно. Эдгээр үзүүлэлт нь DVB-S, S2 технологид адилхан үйлчлэхээр тогтоосон болно.
- ❖ Хөдөлгөөнт холбооны 4 дэх үеийн технологи болох (LTE, LTE-Advanced)-ийн хөгжил, олон улсад хэрэгжүүлж буй бодлого, зохицуулалт, техник технологийн шийдэл сэдвүүдээр дэвшилтэт техник технологийн үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлэгч компаниуд болох Шведийн Ericsson, Хятадын Huawei, ZTE, Францын Alcatel Lucent, Японы KDDI, Солонгосын КТ зэрэг компанийн төлөөлөгчдийг урьж салбарын мэргэжилтэн, судлаачид болон оператор компаниудын төлөөлөгчдийг урин оролцуулж сургалт, семинар зохион байгуулсан. Шинэ технологи болох LTE-ийн давтамжийн нөөцийг бүрдүүлэх, хуваарилалтыг төлөвлөх ажлын хүрээнд 686-790 МГц, 2200-2400 МГц, 2500-2700 МГц-ийн радио давтамжийн зурвасыг чөлөөлөх радио давтамж зохицуулалтын баримт бичгүүдийг боловсруулж, Хорооны 2013 оны ээлжит хуралдааны 12, 29, 46 тоот тогтоолын хавсралтаар тус тус батлуулсан болно.
 - ❖ Радио давтамжийн төлөвлөлт, стратегид дүн шинжилгээ хийх ажлын хүрээнд 2012 он болон өмнөх онд олгогдсон радио давтамжийн ашиглалтыг Улаанбаатар хот болон нийт 18 аймаг, 10 гаруй сумдад радио давтамж ашиглалтын хяналт шалгалтыг хийж, үр дүнг олон нийтэд мэдээлж, хууль бусаар ашиглаж байсан радио давтамжийг чөлөөлөх, хязгаарлагдмал нөөц бүхий радио давтамжийн нөөцийг бүрдүүлэх чиглэлээр ажиллав.
 - ❖ Харилцаа холбооны зохицуулах хорооны 2013 оны 29 тоот тогтоолоор “Тоон телевизийн олон сувгийг олон цэгт түгээх сүлжээний техникийн нөхцөл, зохицуулалтын шаардлага”-ыг боловсруулж, батлуулсан. Мөн тоон телевизийн олон сувгийг олон цэгт түгээх үйлчилгээ эрхлэгчдийн ашиглаж буй радио давтамжийн төлөвлөлт, стратегийг шинэчлэн боловсруулж, уг үйлчилгээнд ашиглагдаж буй 2200-2400МГц, 2500-2700МГц-ын радио давтамжийг хэрхэн ашиглах, чөлөөлөх, шинээр 2700-2900МГц-ийн радио давтамжийн зурвасыг төлөвлөх судалгааг хийж, асуудлыг боловсруулан батлуулав.
 - ❖ ХХЗХ-ны 2002 оны 6 тоот тогтоолоор батлагдсан “Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрлийг өрсөлдүүлэн шалгаруулж олгох журам”-ыг шинэчлэн боловсруулж, тус хорооны хуралдааны 2013 оны 61 тоот тогтоолоор шинэчилэн батлуулав. Өрсөлдүүлэн шалгаруулах журмын хүрээнд хязгаарлагдмал нөөц бүхий радио давтамжийг уралдаант шалгаруулалт эсхүл дуудлага худалдаа гэсэн 2 хэлбэрээр өрсөлдүүлэн шалгаруулж радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл болон үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохоор тус тус тодорхойлсон болно.
 - ❖ Цахилгаан холбооны үйлчилгээ, шуудангийн ашиглалт үйлчилгээ, мэдээлэл холбооны үндсэн сүлжээ байгуулах, түүнийг ашиглах, телевиз, радиогийн олон сувгийг хиймэл дагуулаар дамжуулах, Улаанбаатар хотод телевизийн олон сувгийн үйлчилгээ, мэдээлэл холбооны сувагчлал, дэд бүтэц байгуулах, эзэмших чиглэлүүдээр холбогдох хуулийн дагуу зах зээлийн төвлөрөл, давамгайлалчийг тодруулах судалгааг хийж давамгайлалчийг тодорхойлон санал, дүгнэлтээ холбогдох дэлгэрэнгүй үндэслэлийн хамт ШӨХТГ-д шийдвэрлүүлэхээр хүргүүлсэн. Энэ ажлын хүрээнд ШӨХТГ-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу холбогдох нэмэлт мэдээлэлүүдийг гарган хүргүүлж, мэдээллээр бүрэн хангаж ажиллав.
 - ❖ Шуудангийн үйлчилгээний давуу эрхийн бүсийг шинэчлэн тогтоохоор БНУ-ний үүргийг хүлээж байгаа Монгол шуудан ТӨХК-ийн БНУ -ний алдагдлын судалгааг гаргаж, 2014 онд шуудангийн үйлчилгээний давуу эрхийн бүсээс БНҮҮСанд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг тогтоох саналыг боловсруулан Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн 2013 оны 65 тоот тогтоолоор батлуулав. Тогтоолыг хэрэгжүүлэх асуудлаар БНҮҮС-гийн ажлын албанд албан тоотоор хүргүүлэв.
 - ❖ Шуудангийн үйлчилгээ эрхлэгч байгууллага болон шуудангийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд оролцогч тээвэр зууч, тээвэрлэгч, хил, гаалийн хяналтын байгууллагуудын

дунд “Шуудангийн салбарын хөгжлийн ирээдүй-зохицуулалт-2014” сэдэвт сургалт, хэлэлцүүлгийг 2013 оны 12-р сарын 09-10-ны өдрүүдэд зохион байгууллаа Энэ өдрүүдэд шуудангийн салбарт хэрэгжиж байгаа төрийн бодлого, зохицуулалт, үр дүн, олон улсын шуудангийн туршлага зэрэг сургалт мөн шуудангийн салбарын хөгжлийг хурдасгах түлхүүр хүчин зүйлүүдийн талаар нээлттэй хэлэлцүүлэг болсон бөгөөд хэлэлцүүлгийн үеэр гарсан саналуудыг нэгтэн зөвлөмж гарган холбогдох газруудад хүргүүлэн төлөвлөгөө гарган ажиллаж байна.

- ❖ Монгол Улсын Засгийн газраас 2012 оны 11 дүгээр сараас аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тогтолцоог шинэчилэх, боловсронгуй болгох арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж буй ажлын хүрээнд мэдээлэл, харилцаа холбоо, шуудангийн салбарын зохицуулалтын үйл ажиллагаа, үйлчилгээний тусгай зөвшөөрөл, радио давтамжийн тусгай зөвшөөрөл, бүртгэлийн гэрчилгээний олголт, төлбөр тооцооны механизм, орлогын бүрдүүлэлт ба байгууллагын үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх “Цахим-ХХЗХ” (e-CRC) төслийг боловсруулан үе шаттай хэрэгжүүлж эхлэв. “Цахим-ХХЗХ” төслийн эхний шатанд байгууллагын цахим хуудсын бүтэц, агуулгыг бүрэн шинэчилсэн бөгөөд хорооны дотоод ба зохицуулалтын үйл ажиллагаа, ашиглаж байгаа техник хэрэгсэл ба програм хангамжууд, бичиг хэргийн урсгал, тусгай зөвшөөрлийн олголт ба төлбөр тооцооны механизм, орлогын бүрдүүлэлт үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ хийж, хэрэгжүүлэх үе шат болон арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан Даргын зөвлөл, Хорооны хуралдаанд танилцуулан удирдамж чиглэл авч байгууллагын тусгай зөвшөөрлийн үйлчилгээ, бичиг хэрэг, дотоод гадаад зохицуулалтын ажил үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг, тайлан мэдээлэл ба санхүү төсөв, орлогын мэдээг нэгтгэн боловсруулах, хэрэгжүүлэх оролцооны хамаарал, уялдаа холбоо, хугацааны үечлэл, хүрэх үр дүнг тусгасан ажлын процессын зураглалыг албан хаагч, алба бүрээр гаргаж загварчилах замаар хорооны үйл ажиллагааны үе шат, хугацаа, хүрэх үр дүн, хариуцлагатай болгох, цахим хэлбэрт шилжүүлэх бэлтгэл арга хэмжээг аваад байна. Төслийн хүрээнд албан байрны 5 дугаар давхарт “Үйлчилгээ үзүүлэх цэг” танхим тусгайлан байгуулан тусгай зөвшөөрөл эзэмшигч, иргэн, байгууллагад үзүүлэх ажил, үйлчилгээ болон мэрэгжил арга зүйн зөвлөмжийг шуурхай нэг цэгээс үзүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн болно.
- ❖ Хорооны Даргын 2013 оны 276 тоот тушаалаар ХХЗХ-ноос нэгтгэн гаргадаг салбарын статистик мэдээллийг авч нэгтгэх нийтдээ 12 маягыг шинэчилэн боловсронгуй болгох, цахим хэлбэрээр бөглөх, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мэдээллийн үндсэн сантай холбох, шинэчилэн боловсронгуй болгох ажлын хэсгийг томилон ажиллуулав. Ажлын хэсгээс ажлын хэсгийн боловсруулсан шинэ 14 маягтын загвар, бөглөх заавар, холбогдох мэдээлэл, тайланг Даргын Зөвлөлийн 2013 оны 12 дугаар хуралд танилцуулж, холбогдох өөрчлөлтийг тусган программ зохиогч аж ахуйн нэгжид ажлын даалгавраар хүлээлгэн өгснөөр дээрх маягтуудыг цахим хэлбэрээр бөглөх боломжийг бүрдүүлэн бөглөх зааварчилгааны хамт ашиглахад бэлэн болгож, 2013 оны статистик мэдээллийг цахим хэлбэрээр авах нөхцлийг бүрдүүлэв.
- ❖ Хорооны Даргын 2013 оны 268 тоот тушаалын дагуу тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийн болон тэдгээрийг эзэмшигчдийн талаарх мэдээ мэдээллийн сан, өгөгдлийг шинэ форматад шилжүүлэн шивэх, шалган тулгах, мэдээлийн сан өгөгдлийг цахим хэлбэр программд шилжүүлэх ажлын хэсгийг байгуулан албадууд тусгай зөвшөөрлийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэн туршилтаар ажиллуулж эхэлсэн болно.
- ❖ ХХЗХ-ноос санхүүжүүлэн 2013 онд боловсруулах стандартын жагсаалтыг гарган санал авч, олон нийтэд зарлан гүйцэтгэх багийг шалгаруулан гэрээг байгуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллав. Үүнд: Мэдээллийн технологийн чиглэлээр–3, Харилцаа холбоо, сүлжээний чиглэлээр–6, Тоон телевиз, радиогийн чиглэлээр–2, Шуудангийн чиглэлээр–3, Мэдээлэл харилцаа холбооны баталгаажуулалтын чиглэлээр–15 зэрэг

- болно. 2013 оны эцсийн байдлаар, мэдээллийн технологи, шуудан, баталгаажуулалт, телевизийн өргөн нэвтрүүлгийн чиглэлээр нийтдээ 10 гаруй үндэсний стандартыг эрх бүхий байгууллага болох Стандартчилал, хэмжил зүйн газрын Үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн үндэсний стандартаар батлуулаад байна.
- ❖ Гадаад хамтын ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд ОУЦХБ, АНДЦХБ, ХБНГУ-ын Баталгаажуулалтын байгууллага, ИБУИНВУ, БНАСАУ, БНХАУ-ын Хонг Конг, Тайвань, БНСУ-ын зохицуулах байгууллага, судалгааны хүрээлэн, БНСУ-ын Кореа телеком, Японы КДД-Ай, сансарын холбооны байгууллага, компанитай хамтран ажиллав.
 - ❖ ХХЗХ-ноос 2013 онд төсөл боловсруулан хүсэлт тавьсаны дагуу БНСУ-ын Мэдээлэл хөгжлийн институтээс /KISDI/ Давтамж удирдлага, бодлого зохицуулалтын чиглэлээр 1 жилийн хугацаатай 350 мянган ам.долларын өртөг бүхий зөвлөх үйлчилгээний төслийг хэрэгжүүлэв. Зөвлөх үйлчилгээний хүрээнд БНСУ-ын KISDI, ETRI, CRMO, KORPA зэрэг байгууллагын эрдэмтэн, мэргэжилтнүүдийн багтай хамтран Монгол улсын үндэсний радио давтамжийн бодлого, зохицуулалт сэдэвт сургалт семинарыг Монголд 3 удаа, БНСУ-ын Сөүл хотноо 1 удаа тус тус зохион байгуулсан.
 - ❖ ХХЗХ болон БНСУ-ын зохицуулах байгууллагатай байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд 2013 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр БНСУ-ын “Радио долгион хяналтын суурин станц бэлэглэх, суурилуулах гэрээ”-нд гарын үсэг зурсан юм. Энэхүү буцалтгүй тусламжийн хүрээнд 2013 оны 10 дугаар сарын 1-нээс эхлэн радио долгион хяналтын суурин станцын угсралт суурилуулалт, тохиргоо болон сургалтыг амжилттай зохион байгуулж 2013 оны 10 дугаар сарын 24-ний өдөр албан ёсоор хүлээлгэн өглөө. Энэхүү “Радио долгион хяналтын суурин станц” нь Олон улсын цахилгаан холбооны байгууллагын стандарт, шаардлагад бүрэн нийцсэн хамгийн сүүлийн үеийн ухаалаг, өндөр технологийн систем юм. Энэ радио долгион хяналтын суурин станцын хамрах хүрээ нь нийслэл хотын төвийн хэсгийг бүрэн хамрах бөгөөд бусад хөдөлгөөнт болон зөөврийн хяналтын станцтай хослон ажиллаж хууль бус радио долгионы үүсгүүрүүдийг илрүүлэх, радио давтамжийн харилцан нөлөөллийг 24 цагийн турш хянах, илрүүлэх боломжтой систем юм.
 - ❖ Хорооны хуралдаанаас шинээр батлагдсан, шинэчилсэн, нэмэлт өөрчлөлт оруулсан зохицуулалтын чиглэл, дүрэм журам, нөхцөл шаардлагыг байгууллагын цахим хуудсанд цаг тухай бүрд нь байрлуулж, олон нийтэд хүргэх арга хэмжээг авч ажилласан. Тайлангийн хугацаанд байгууллагын вэбсайт-д ХХЗХ-ны тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх, байгууллагын үйл ажиллагааг сурталчилах, шинэ дүрэм журам болон техник технологийн мэдээ, хэлэлцүүлэг, уулзалтын үр дүн, зарлал, мэдээлэл зэрэг чиглэлээр нийт 145 Мбит багтаамж бүхий 52 материалыг шинээр байршуулсан ба 8 он-лайн хэлэлцүүлэг, санал авах 6 хуудсыг тус тус байрлуулан оруулав. Салбарын зохицуулалтын баримт бичиг, дүрэм журам, тусгай зөвшөөрлийн шинээр батлагдсан, шинэчилсэн, нэмэлт өөрчлөлт оруулсан журам, нөхцөл шаардлага болон 2013 оны хорооны хуралдааны шийдвэр, тогтоолын нийтдээ 52 хуудсыг татах файлын хамт HTML хэлбэрээр оруулж, олон нийтэд нээлттэй сурталчилах, зөвлөмж гарын авлага хэлбэрээр ашиглах боломжийг бүрдүүлэв.
 - ❖ “ХХЗХ-ны мэдээ” сэтгүүлийн 2013 оны 1 дэх, 2 дахь дугаарын агуулга, бүтцийг боловсруулан 2013 он 5 дугаар сард 1500 ш, 11 дүгээр сард 1000 ш тус тус хэвлүүлэн иргэд, тусгай зөвшөөрөл эзэмшигч нарт үнэ төлбөргүй өгөх, үзэсгэлэн, уулзалт семинар, хэлэлцүүлэг, семинарын үеэр түгээж өөрийн байгууллагын үйл ажиллагаа, 2013 онд шинэчилсэн зохицуулалтын дүрэм журам, нөхцөл шаардлагыг сурталчилав. Хорооны цахим хуудсанд “Үйлчилгээ эрхлэгчдийн боловсролд” нэртэй цэс нээж холбогдох зөвлөмж, гарын авлага, видео хичээл, танилцуулга, судалгааны материал, холбогдох линкийг байршуулан тайлант хугацаанд хийсэн шалгалтуудын хураангуй тайлан, 2008 оноос хойш бүсийн семинарын илтгэлүүдийг хөтөлбөрийн хамт байршуулсан.

- ❖ ХХЗХ-ноос телевизийн үйлчилгээ эрхлэгчдэд зориулан “Телевизийн сэтгүүлзүйн үндсэн ойлголт зөвлөмж” 300ш хэвлүүлэн, Радиогийн уран бүтээлчдэд зориулсан “Бид Радио сонсож байна” 100ш гарын авлага ном худалдан авч, Төвийн бүсийн сургалт, семинарт оролцсон телевиз, радиогийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үнэ төлбөргүй өгч гарын авлагаар хангаж ажилласан.
- ❖ ХХЗХ-ны санхүүгийн дэмжлэгтэйгээр “Сэтгүүлчийн ёс зүй, эфирийн соёл” нэртэй нэвтрүүлгийг Монгол ТВ-д захиалан хийлгэж, 2013 оны 7 дугаар сард эфирээр нэвтрүүлэн мэргэжил, арга зүйн зөвлөмж хангаж ажиллав. Түүнчлэн уг нэвтрүүлэгт тулгуурлан “Сэтгүүлчийн ёс зүй”, “Эфирийн соёл” сэдвээр 30 минутын цуврал 2 видео хичээл захиалан хийлгэж, Зохицуулах хорооны цахим хуудас дээр тавьж сурталчилах арга хэмжээг авлаа.
- ❖ ХХЗХ нь мэдээлэл, харилцаа холбооны салбарын өнөөгийн хөгжил, бодлого, зохицуулалтын асуудлуудын чиглэлээр бүсийн семинарыг 2006 оноос эхлэн жил бүр зохион байгуулж ирсэн уламжлалтай бөгөөд энэ удаагийн Төвийн бүсийн семинар, сургалтыг “Харилцаа холбооны зохицуулалт, хөгжлийн чиг хандлага-2013” сэдвээр Өвөрхангай аймгийн төв Арвайхээр суманд 2013 оны 11 дүгээр сарын 6-7-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Семинарын гол зорилго нь тус салбарт 2013 онд хэрэгжүүлсэн бодлого, зохицуулалтын өөрчлөлтийн талаар мэдээлэл өгөх, тулгамдаж буй асуудлуудын шийдлийг хэлэлцэх, мэдээлэл харилцаа холбооны салбарт хийсэн зохицуулалтын гол үйл ажиллагааны шинэчлэл, дүрэм журам, нөхцөл шаардлагын шинэчлэлтийг нэгтгэн бүс нутгийн тусгай зөвшөөрөл эзэмшигч, иргэд байгууллага, салбарын хамт олонд танилцуулах, дэлхий нийтийн харилцаа холбооны чиг хандлага, сүүлийн үеийн техник технологийн дэвшлийн талаар туршлагыг сурталчилах, , мэргэжил арга зүйн зөвлөмжийг өгөх, цаашид салбарын хэмжээнд бодлого, зохицуулалт, тоон өргөн нэвтрүүлэгт шилжих хөтөлбөрийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, санал санаачлагуудыг ХХЗХ, МТШХХГ, тусгай зөвшөөрөл эзэмшигчид, ТББ-ын төлөөлөл, хэрэглэгч нар хамтдаа хэлэлцэв. Бүсийн семинар, сургалтанд Архангай, Өвөрхангай, Төв, Дундговь, Өмнөговь болон Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрт мэдээлэл, шуудан, харилцаа холбооны үйлчилгээ явуулж буй аж ахуйн нэгж, иргэдийн нийт 80 гаруй төлөөлөгчид оролцлоо.
- ❖ Тоон телевизийн өргөн нэвтрүүлэг, хиймэл дагуулын технологи ба зохицуулалт, домэйн нэр, радио давтамжийн төлөвлөлт зохицуулалт, үүрэн холбооны 4 дэх үе, радио холбооны шинэ техник технологийн ололтыг сурталчилах, нутагшуулах, холбогдох мэргэжил арга зүйн зөвлөмж өгөх, зохицуулалтыг хэрэгжүүлэх чиглэлээр сургалт, семинар, уулзалт, хэлэлцүүлэг 20 гаруй удаа зохион байгуулав. Үүнд: Телевизийн өргөн нэвтрүүлгийн зохицуулалт-2013 семинар, Төвийн бүсийн семинар, сургалтыг “Харилцаа холбооны зохицуулалт, хөгжлийн чиг хандлага-2013” сэдвээр Өвөрхангай аймгийн төв Арвайхээр суманд, Шуудангийн зохицуулалт-2014 сэдэвт семинарыг 2013 оны 12 дугаар сард Улаанбаатар хотноо тус тус зохион байгуулав.
- ❖ “Шинэчлэлтийн Засгийн газар 1111 Төв”-д мэдээллийн технологи, харилцаа холбоо, шуудангийн үйлчилгээ болон зохицуулалтын чиглэлээр тус хороонд 2012 оны 10 дугаар сараас 2013 оны 11 сар хүртэлх хугацаанд иргэдээс нийтдээ 1100 гаруй гомдлыг хуулийн хүрээнд тогтоосон хугацаанд нь шийдвэрлэв. Иргэдээс төрөл бүрийн сувгаар мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний талаархи өөрийн санал бодлыг илэрхийлж, асуудлаа шийдвэрлүүлэхээр хандаж байгаа бөгөөд үйлчлэгч компанийн шийдвэрлэлтэд сэтгэл хангалуун бус байснаас эсхүл үйлчлэгчтэйгээ холбогдож чадахгүй байх зэрэг шалтгааны улмаас тус төвд ханддаг. Нийт шийдвэрлэсэн санал гомдолд: Кабелийн телевиз (Айпи телевиз орсон)-тэй холбоотой санал гомдол 36 %, Эфирийн радио, телевиз –28 %, Үүрэн холбоо-13%, Интернэт-14 %, Тусгай дугаар, веб сайт тус бүр -2%, Үлдэж буй 5%-ийг

суурин холбоо, шуудан, богино долгионы радио станц, тусгай зөвшөөрөлтэй холбоотой санал хүсэлт эзэлж байсан болно.

Хоёр. Удирдлагаас өгсөн чиглэл, үүрэг даалгаарын хүрээнд:

- ❖ Харилцаа холбооны салбарын бодлого чиглэл, зохицуулалтын чиглэлээр Засгийн газрын бодлого чиглэл, тогтоол шийдвэр, хөтөлбөр боловсруулахад санал өгч МХЕГ, ШӨХТГ, ЦЕГ, ГЕГ, ТЕГ, КАБГ, ШУТИС, НТГ зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт ярилцлага зохион байгуулж хамтран ажиллах санамж бичиг байгуулан ажиллав.
- ❖ ХХЗХ, ОӨГ, ШӨХТГ, НМХГ, НЦГ-ын Даргын нарын баталсан удирдамжийн дагуу Улаанбаатар хотод телевизийн болон кабелийн сувгийн үйлчилгээ эрхлэгчдийн тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын хэрэгжилтэнд хяналт шалгалт хийх, үнэлгээ өгөх, холбогдох арга хэмжээг авч ажиллах ажлын хүрээнд 17 өргөн нэвтрүүлгийн телевизүүдэд, кабелийн сувгийн үйлчилгээ эрхэлдэг 44 аж ахуйн нэгж байгууллага, иргэдийг хяналт шалгалтанд хамруулав. Хяналт шалгалтаар стандарт, шаардлага хангаагүй зөрчил гаргасан 20 гаруй кабелийн сувгуудад улсын байцаагчийн дүгнэлт гаргасаны дагуу ХХЗХ-ны тогтоолоор үйл ажиллагааг нь түр хугацаагаар түтгэлзүүлэн, хэрэгжилтэнд нь хяналт тавьсан.
- ❖ Тус хорооны 2013 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны “Дотоод аудитын тогтолцоог туршилтаар нэвтрүүлэх зарим арга хэмжээний тухай” 3 дугаар Тэмдэглэлээр байгууллагын хэмжээнд дотоод аудитын тогтолцоог аудиторын баг сонгон шалгаруулах зарчмаар 2014 оны эхний хагас жил, жилийн тайланд туршилтын журмаар нэвтрүүлэх, дотоод аудитын тогтолцоог байгууллагын хэмжээнд туршилтаар нэвтрүүлэхтэй холбоотой гарах төсөв, зардлыг 2014 оны Ерөнхий менежерийн бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээнд тусгах, холбогдох дүрэм журам шинээр боловсруулах, бусад дүрэм журамд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хийх, шинэчилэх арга хэмжээг 2014 оны 1 дүгээр улиралд багтаан тус тус хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд үүрэг болгон шийдвэрлэсэн болно.
- ❖ ХХЗХ-ноос санаачилан “Өндөр хурдны өргөн зурвасын сүлжээ үндэсний хөтөлбөр”-ийн биелэлт болон цаашид оруулах шаардлагатай нэмэлт өөрчлөлтийн талаар МТШХХГ-тай уулзалт хийж санал солилцож, хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын байдлыг заалт бүрээр гаргасан болно.
- ❖ ХХЗХ-ноос нийтдээ 12,6 сая ам.долларын өртөг бүхий “Үндэсний радио долгион хяналтын төсөл”-ийн саналыг боловсруулж, холбогдох танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий Сайдад 2013 оны 8 сард хийсэн болно.
- ❖ ХХЗХ-ны Дарга болон МТШХХГ-ын Дарга нарын 2013 оны хамтарсан тушаалаар байгуулсан ажлын хэсгээс төсвийн болон гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр 2005 оноос хойш хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж буй төслүүдийг судлан, төслүүдийн хүлээлгэн өгсөн тоног төхөөрөмж, бүтээгдэхүүний өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгч ашиглалт болон төслийн хэрэгжилтийн байдалд судалгаа хийж төсөл тус бүрийн зураглалыг хийж гүйцэтгэсэн. Ажлын хэсгийн тайлан, дүгнэлтийг МТШХХГ, ХХЗХ-ны удирдлага болон Монгол Улсын Ерөнхий сайдад танилцуулсан болно.
- ❖ Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 275 тоот тогтоолоор батлагдсан “Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус Хорооны Даргын 2013 оны 100 тоот тушаалаар “Тоон радиогийн зохицуулалтын чиглэл, техникийн шийдэл боловсруулах” ажлын хэсгийг ХХЗХ, МТШХХГ, ШУТИС-ийн МХТС, РТС ТӨҮГ болон бусад судалгааны байгууллагын төлөөллүүдийг оролцуулан байгуулж ажиллан, холбогдох тооцоо судалгаа, хэрэгжүүлэх хувилбарын санал, хөрөнгө оруулалтын тооцоог боловсруулсан болно.

- ❖ Нийслэл хотын телевизийн өргөн нэвтрүүлгийн аналогийн дахин дамжуулах станцуудыг DVB-T2 системийн тоон телевизийн дамжуулах станцад шаардлагатай тоног төхөөрөмжийн техникийн нөхцөл шаардлагын төслийг боловсруулж, холбогдох саналуудыг албан бичгээр МТШХХГ, болон Нийслэлийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн.
- ❖ Улаанбаатар хот болон орон нутагт ашиглагдах радио давтамжийн төлөвлөлт, хуваарилалтыг нийслэл хот болон сум, аймаг тус бүрээр нарийвчлан гаргаж боловсруулан Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны 2013 оны 28 тоот тогтоолын хавсралтаар батлуулан мөрдөж эхлэв.
- ❖ Тус хорооны тусгай зөвшөөрөл, бүртгэлийн гэрчилгээ, тусгай дугаарын мэдээллийн сан болон тусгай зөвшөөрөл эзэмшигчидийн хаяг байршлын мэдээллийг шинэчлэх, өөрчлөлтийг бүртгэн, мэдээллийн сан, өгөгдлийг шинэ форматад шилжүүлэн шивэх, шалган тулгах, мэдээллийн сан өгөгдлийг цахим хэлбэр, программд шилжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг Хорооны Даргын 2013 оны 268 тоот тушаалаар байгуулан ажиллав. Тус ажлын хэсгээс тусгай зөвшөөрлийн нэгдсэн цахим мэдээллийн санг бүрдүүлэхдээ холбогдох түүхийн хамт шивж оруулан тулгалт хийж тусгай зөвшөөрлийн болон радио давтамж ашигласны төлбөрийн програм хангамжийн үндсэн суурь болгон ашиглахаар санал боловсруулан 2013 оны Даргын Зөвлөлийн 11 дүгээр хуралдаанд танилцуулан программын зүгшрүүлэлт хийлээ. Тусгай зөвшөөрлийн мэдээллийн сан, өгөгдлийг шинэ форматад шилжүүлэх өгөгдлийг цахим хэлбэр, программд шилжүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг нь тус ажлын хүрээнд 8 багана 1692 мөр бүхий харилцагчийн бүртгэл, 9 багана 2989 мөр бүхий тусгай зөвшөөрлийн бүртгэлийг хянаж шинэ системд хөрвүүлсэн. Авлага, орлого болон төлөлтийн тайлангийн 3037 мөр 14 баганатай мэдээлэлийг боловсруулж бэлтгэн программд хөрвүүлэх ажлыг хийж, мэдээллийн санг бүрдүүлээд байна. 2014 оноос турших бэлтгэлийг хангасан болно.
- ❖ Спектр менежментийн программд радио давтамжийн тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийн холбогдолтой 150 сайтын мэдээллийг 2013 онд шивэн оруулсан. Уг программыг ашиглан тоон телевизийн сүлжээний тооцооллыг хийсэн бөгөөд нийт 150 сум суурингийн хамрах хүрээний тооцооллыг боловсруулав. Шуудангийн тусгай зөвшөөрөл шинээр авсан болон сунгалт, өөрчлөлт оруулсан аж ахуйн нэгж, байгууллагын регистр, улсын бүртгэлийн дугаар, сунгалтын хугацаа, төлбөр, эзэмшигчийн мэдээллийг цаг тухай бүр нь мэдээллийн санд баяжилт хийж ажиллаа.
- ❖ Тус хорооноос ГЕГ-тай хамтарсан ажлын хэсгийг Хорооны Даргын тушаалаар байгуулж, 2013 оны 11 сард хамтарсан шалгалт хийлээ. Тус газартай хамтран ажиллах Санамж бичиг байгуулж, холбогдох дүрэм, журамд өөрчлөлт оруулах саналаа ГЕГ-ын Мэргэжлийн зөвлөлд хэлэлцүүлж, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах ажлын хэсэгт албан тоотоор хүргүүлэв.
- ❖ Радио давтамж ашиглах эрхийн бичиг эзэмшигч харуул хамгаалалт, таксиний үйлчилгээ эрхлэгч байгууллагуудад хууль тогтоомж болон радио давтамжийн төлөвлөлт, хуваарилалт, төлбөр хураамжийн талаар сургалт семинар зохион байгуулж оролцогч байгууллагуудыг шинээр гарсан зохицуулалтын баримт бичиг, заавар зөвлөмжөөр хангасан.

Гурав. Бусад ажлын хүрээнд:

- ❖ Тус хорооноос 2012 оны УИХ-ын сонгуулийн сурталчилгааны мониторинг шалгалтын ажлын хэсгийн дүн болон Улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн Монгол УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 35.11 дэх заалтыг зөрчин телевизээр сонгуулийн сурталчилгааг хоногт 2 цагаас илүү хэтрүүлэн нэвтрүүлсэн 14 ААН, байгууллагад Монгол УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 35.33 дахь заалтыг үндэслэн зөрчлийн тухай

тэмдэглэл хөтлөн нийт 13 телевизэд холбогдох торгууль ноогдуулан зөрчлийн арилгуулав.

- ❖ ХХЗХ-д Дэлхийн банкны санхүүжилтээр 2012-2013 онд хэрэгжиж байгаа “Тусгай зөвшөөрлийн тогтолцоог боловсронгуй болгох” зөвлөх үйлчилгээний төслийн хүрээнд Австрали, Сингапур, Хонгконг, Брунэй, Европын холбоо зэрэг улсуудын тусгай зөвшөөрлийн талаарх материал, олон улсын туршлагын талаар мэдээллийн сан бүрдүүлсэн бөгөөд чиглэл бүрт хариуцсан мэргэжилтэнгүүд олон улсын зохицуулалтын чиг хандлага, зохицуулалт хийсэн туршлага зэргийг судлан, танилцуулга мэдээллийн санг бүрдүүлсэн. 1.4.2 дахь ТЗ-ийн маягтуудыг боловсруулахдаа олон улсын зохицуулах байгууллагуудын тусгай зөвшөөрлийн өргөдлийн маягтын загвар, холбогдох баримт бичгүүдийг судалсны үндсэн дээр шинэчилэн боловсруулав.
- ❖ ХХЗХ-ноос санхүүжүүлэн Глоб Интернэшнл ТББ-тай хамтран ЮНЕСКО байгууллагаас гаргасан “Хэвлэл мэдээллийн шалгуур үзүүлэлт”-ийг ашиглан Монголын хэвлэл мэдээллийн орчинд үнэлгээ хийж, дүгнэлт өгөх судалгааны тайланг салбарынхны дунд хэлэлцүүлж, зөвлөмж боловсруулах зорилготой “Хэвлэл мэдээллийн үндэсний бага хурал” сэдэвт форумыг 2013 оны 10 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд зохион байгуулав.
- ❖ Шуудангийн бүх нийтийн үйлчилгээг тодорхойлох саналыг эдийн засгийн үндэслэл, тооцоог хийж санал боловсруулан засгийн газарт хүргүүлэн Ерөнхий сайдын 24 тоот захирамжаар батлуулав.
- ❖ Монгол Улсад DVB-T2 телевизор борлуулж байгаа М-Си-Эс Электроникс, Некст электроникс, Номин электроникс, Саммит Компьютер Технологи зэрэг электрон барааны дэлгүүрүүдийн төлөөлөгчидтэй уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулан тоон телевизорын давуу тал, тавигдах шаардлага, заавал болон сайн дурын баталгаажуулалтад хамруулах боломж, стандарт техникийн нөхцөл шаардлага, иргэдийг холбогдох мэдээллээр хангах замаар хэрэглэгчид зах зээл дээр бүтээгдэхүүний талаар илүү оновчтой шийдвэр гаргах боломжтой стандартад нийцсэн чанартай телевизор хэрэглэх, зөв худалдан авалт хийхэд нь туслах зэрэг сэдвээр ярилцах, тус хорооны вэб хуудсаар дамжуулан санал асуулга явуулах ажлын зохион байгуулсан.
- ❖ Байгууллагын вэб хуудсыг бүтэц загвар дизайн програмчлалын хувьд бүрэн шинээр хийж 2013 оны 2 дугаар улиралд багтаан бүрэн дуусгасан. Монгол хувилбар дээр 6 үндсэн цэс 71 дэд цэсүүд, нүүрэн хэсэгт 9 бүлэг болгон хувааж холбогдох мэдээллүүдийн оруулав. Англи хувилбар дээр 6 үндсэн цэс 23 дэд цэсүүд, нүүрэн хэсэгт 5 бүлэг болгон хувааж холбогдох мэдээллүүдийн оруулав. Тайлант хугацаанд нийт 160 гаран мэдээ мэдээлэл түүнд харгалзах зургууд, 210 үндсэн хуудас дагалдах текст мэдээллүүд, 184 html хэлбэртэй харагдах дүрэм журам, нөхцөл шаардлага түүнд дагалдан татан авч болохуйц PDF форматын файлууд орсон.Цахим хуудсанд зөвхөн татаж авч үзэх боломжтой 108 файл ба ухаалаг гар утас, таблетууд дээр үзэхэд хүндрэлтэй байсныг харагдах байдлыг текстэн (HTML) форматад оруулж өгсөнөөр шууд үзэх бололцоотой болсон, Тусгай зөвшөөрлийн шинээр батлагдсан журам, нөхцөл шаардлага, хурлаас гарсан тогтоолуудыг холбогдох ажилтнуудаас авч 52 хуудсыг татах файлын хамт текстэн (HTML) хэлбэрээр оруулсан. Зохицуулах байгууллагын үе үеийн удирдлагууд, Радио хяналтын төв, Видео булан, хэрэглэгчийн гэрээний нөхцөлүүд, хуралдааны шийдвэр, ажил үйлчилгээний зар, бүсийн семинар 2013, шуудангийн салбарын хөгжлийн ирээдүй зохицуулалт 2014, Ерөнхийлөгчийн сонгууль 2013, мэдээллийн ил тод, шинээр зарлагдсан ажлын байрны зар гэсэн булан үүсгэж холбогдох мэдээлэл илтгэлүүдийг зургийн хамт нэгтгэн оруулсан.2007- 2012 онуудын салбарын статистик мэдээллүүдийг шууд үзэх боломжтой хэлбэрээр оруулсан.
- ❖ Байгууллагын баримт бичиг нягтлан шалгах комиссыг Хорооны Даргын 2013 оны 04 сарын 12-ний өдрийн 99 тоот тушаалаар шинэчлэн байгуулсан. Тус комиссын 3 удаагийн хурал зохион байгуулж, архивын баримтанд тооллого хийж, Баримт бичиг нягтлан шалгах

комиссын хурал хуралдуулах, Архивын баримтын нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний төслийн хэлэлцэн шийдвэрлсэн болно.

- ❖ Хорооны архивын өрөөг нүүлгэн шилжүүлэхтэй холбогдуулан Хорооны Даргын 2013 оны 184 тоот тушаалаар Тооллого хийх комиссыг байгуулан, архивын баримтанд тооллого хийж баримтын жагсаалтыг шинэчлэн гаргалаа. Тооллогын дагуу гаргасан жагсаалтаар тус хорооны архивт Байнга хадгалах 491, түр хадгалах 506, видео баримт 172, дуу авианы баримт 23 байхаар шийдвэрлэж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллав.
- ❖ Хорооны цахим хуудсанд “Үйлчилгээ эрхлэгчдийн боловсролд” нэртэй цэс нээж холбогдох зөвлөмж, гарын авлага, видео хичээл, танилцуулга, судалгааны материал, холбогдох линкийг байршуулан тайлант хугацаанд хийсэн шалгалтуудын хураангуй тайлан, 2006 оноос хойш бүсийн семинаруудаар хийж байсан илтгэлийг илтгэгчийн нэр, хөтөлбөрийн хамт байршуулж, сурталчилах арга хэмжээг авлаа.
- ❖ Түүнчлэн хорооны цахим хуудсанд “Хэрэглэгчийн булан ” нэртэй дэд цэс нээж холбогдох зөвлөмж, эрхзүйн мэдээлэл, олон улсын байгууллагын зөвлөмжийг орчуулж байршуулан тогтмол шинэчлэн баяжуулах ажлыг хийж ажиллсан болно.

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО
2013-12-31

**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ХУРАЛДААНААС 2013 ОНД ГАРГАСАН ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН
НЭГДСЭН СУДАЛГАА**

2013.12.30

№	Хорооны баталсан тогтоол, тэмдэглэлийн дугаар	Огноо	Тогтоол, тэмдэглэлийн товч агуулга
Нэг. ХХЗХ-ны баталсан тогтоол			
1	Тогтоол 01	2013.01.11	Тусгай зөвшөөрөл түдгэлзүүлэх тухай (Кабелийн сувгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл)
2	Тогтоол 02	2013.01.11	Нөхцөл, шаардлагад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (Радио, телевизийн өргөн нэвтрүүлэг зохицуулалтын ерөнхий нөхцөл, шаардлага)
3	Тогтоол 03	2013.01.11	Тендерийн ажлыг зохион байгуулах тухай (Чиглэл хайх систем бүхий зөөврийн хяналт станц, бусад тоног төхөөрөмж)
4	Тогтоол 04	2013.02.27	Нөхцөл, шаардлагад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (Тоон контентын үйлчилгээний ерөнхий нөхцөл, шаардлага)
5	Тогтоол 05	2013.02.27	Журам батлах тухай (Сайтууд дахь сэтгэгдлийн харилцааг зохицуулах журам)
6	Тогтоол 06	2013.03.01	Тариф хянан батлах тухай (Мобикомын тарифын доод хязгаар: 2013.03.15 эхлэх)
7	Тогтоол 07	2013.03.01	Тусгай зөвшөөрөл түдгэлзүүлэх, анз тогтоох тухай (ТВ үйлчилгээ эрхлэгч:1+7)
8	Тогтоол 08	2013.03.01	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох, сэргээх тухай (Кабелийн суваг:9+5+7)
9	Тогтоол 09	2013.03.01	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай (ТВ ӨН-2, РД-2+2, Дэд бүтэц-4)
10	Тогтоол 10	2013.03.01	Тусгай зөвшөөрөл түдгэлзүүлэх тухай (Шуудан: 2, хугацаа: 3 сар)
11	Тогтоол 11	2013.03.01	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай (Шуудан: 4)
12	Тогтоол 12	2013.03.01	Давтамжийн зурвасын зохицуулалтын чиглэл батлах тухай (Давтамжийн 470-690 МГц зурвас)
13	Тогтоол 13	2013.03.01	Зарим нөхцөл шаардлага, журам, зохицуулалтын баримт бичиг хүчингүй болгох тухай (Нөхцөл шаардлага:1, журам:2, Зохицуулалтын баримт бичиг:1)
14	Тогтоол 14	2013.03.01	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох, тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах тухай (Интернэт: 15 хүчингүй, РД:2 өөрчлөлт оруулах)
15	Тогтоол 15	2013.03.15	Тендер шалгаруулалтын дүнгийн тухай
16	Тогтоол 16	2013.03.15	Давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага батлах тухай (UHF: 340-350 МГц зурвас)
17	Тогтоол 17	2013.03.15	Давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага

			батлах тухай (UHF: 400-430 МГц зурвас)
18	Тогтоол 18	2013.03.15	Давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага батлах тухай (UHF: 440-450 МГц зурвас)
19	Тогтоол 19	2013.04.05	Журам батлах, эрх олгох тухай (Радио, телевизээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх журам)
20	Тогтоол 20	2013.05.01	Нөхцөл, шаардлага шинэчлэн батлах тухай (Ай-Пи телевизийн-IPTV үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага)
21	Тогтоол 21	2013.05.01	Аргачлал батлах тухай (Телевиз, радиогийн олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн сувгийн бүтцийг хянах аргачлал)
22	Тогтоол 22	2013.05.01	Нөхцөл, шаардлага шинэчлэн батлах тухай (Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага)
23	Тогтоол 23	2013.05.01	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох, хамрах хүрээнд өөрчлөлт оруулах тухай
24	Тогтоол 24	2013.05.01	Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (Монгол Улсын нутаг дэвсгэрт радио сонирхогчийн эрхийн бичиг олгох журам)
25	Тогтоол 25	2013.05.01	Нөхцөл, шаардлага батлах тухай (Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглах харилцааны радио станцад тавигдах техникийн болон ашиглалтын нөхцөл, шаардлага)
26	Тогтоол 26	2013.05.01	"Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны сүлжээний зохицуулалт" батлах тухай
27	Тогтоол 27	2013.06.28	Журам батлах тухай (Баталгаажуулалтын баримт бичгийн хяналтын журам, шинжилгээ хийх журам, чанарын гарын авлага, холбогдох дүрэм журам, гэрээний загвар)
28	Тогтоол 28	2013.06.28	Давтамжийн зурвас хуваарилах тухай (Нийт аймаг, сумдын тоон телевизийн өргөн нэвтрүүлэгт ашиглах зөөгч сувгийн төлөвлөлт: 2013-2014 он)
29	Тогтоол 29	2013.06.28	Давтамжийн зурвасын тухай (Давтамжийн зурвасын зохицуулалтын чиглэл: 2200-2400 ГГц, 2500-2700 ГГц, 2700-2900 ГГц зурвас, нөхцөл шаардлага)
30	Тогтоол 30	2013.06.28	Тендер зохион байгуулах тухай (Чиглэл хайгч систем бүхий зөөврийн хяналтын станц, өргөн нэвтрүүлгийн хэмжүүрийн тоног төхөөрөмж)
31	Тогтоол 31	2013.06.28	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох, түдгэлзүүлэх, өөрчлөлт оруулах, сэргээх тухай (ЗА, РДХЗА: хүчингүй болгох-11+1+1, сэргээх-1, хамрах хүрээнд өөрчлөлт оруулах-1+1, түдгэлзүүлэх-1)
32	Тогтоол 32	2013.06.28	Тусгай зөвшөөрлийн эрх сэргээх, хүчингүй болгох тухай (Шуудан: сэргээх-2, хүчингүй болгох-3+1)
33	Тогтоол 33	2013.06.29	Нөхцөл, шаардлага шинэчлэн батлах тухай (Сүлжээ байгуулах, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн ерөнхий нөхцөл, шаардлага)
34	Тогтоол 34	2013.06.29	Нөхцөл, шаардлага шинэчлэн батлах тухай (Телевиз радиогийн олон суваг дамжуулах тусгай зөвшөөрлийн тусгай нөхцөл шаардлага)
35	Тогтоол 35	2013.06.29	Нөхцөл, шаардлага шинэчлэн батлах тухай

			(Телевиз радиогийн өргөн нэвтрүүлэг, кабелийн сувгийн тусгай зөвшөөрлийн тусгай нөхцөл шаардлага)
36	Тогтоол 36	2013.06.29	Нөхцөл, шаардлага шинэчлэн батлах тухай (Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага)
37	Тогтоол 37	2013.06.29	Журам шинэчилэн батлах тухай (Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам)
38	Тогтоол 38	2013.06.29	Тусгай нөхцөл, шаардлага батлах тухай (Мэдээлэл холбооны сүлжээ, дэд бүтэц байгуулах тусгай зөвшөөрлийн тусгай нөхцөл шаардлага)
39	Тогтоол 39	2013.08.30	Ажлаас чөлөөлөх тухай
40	Тогтоол 40	2013.08.30	Ажилд томилох тухай
41	Тогтоол 41	2013.08.30	Ажлаас чөлөөлөх тухай
42	Тогтоол 42	2013.08.30	Ажилд томилох тухай
43	Тогтоол 43	2013.08.30	Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (Мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн загварыг баталгаажуулах журам)
44	Тогтоол 44	2013.08.30	Радио давтамжийн зурвасын зохицуулалт, техникийн нөхцөл шаардлага батлах тухай (Давтамжийн 2.4 ГГц-ийн зурвас)
45	Тогтоол 45	2013.08.30	Радио давтамжийн зурвасын зохицуулалт, техникийн нөхцөл шаардлага батлах тухай (Давтамжийн 5 ГГц-ийн зурвас)
46	Тогтоол 46	2013.08.30	Зохицуулалтын чиглэлийг шинэчилэн батлах тухай (Давтамжийн 2.5-2.7 ГГц-ийн зурвас)
47	Тогтоол 47	2013.08.30	Тендер зохион байгуулах тухай
48	Тогтоол 48	2013.08.30	Тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
49	Тогтоол 49	2013.09.06	Нөхцөл шаардлага шинэчлэн батлах тухай (Хавсралт-1:Интернэтийн үйлчилгээ эрхлэх тусгай нөхцөл шаардлага, Хавсралт-2: Улс хоорондын сүлжээ байгуулах тусгай нөхцөл шаардлага)
50	Тогтоол 50	2013.09.06	Нөхцөл шаардлага шинэчлэн батлах тухай (Монгол Улсын нутаг дэвсгэрийг дамжин өнгөрөх улс хоорондын транзит урсгал дамжуулах үйлчилгээ эрхлэхэд тавигдах нөхцөл шаардлага)
51	Тогтоол 51	2013.09.06	Тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
52	Тогтоол 52	2013.09.20	Тусгай нөхцөл, шаардлагад өөрчлөлт оруулах тухай (Телевиз, радиогийн олон суваг дамжуулах тусгай зөвшөөрлийн тусгай нөхцөл шаардлага)
53	Тогтоол 53	2013.09.20	Нөхцөл шаардлагад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (Мэдээлэл, холбооны сүлжээ, дэд бүтэц байгуулах тусгай зөвшөөрлийн тусгай нөхцөл шаардлага)
54	Тогтоол 54	2013.09.20	Ангилалд өөрчлөлт оруулах тухай (Шуудан: Харилцаа холбооны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн ангилал)
55	Тогтоол 55	2013.09.20	Тариф хянах тухай (Монгол шуудан ТӨХК-ийн үндсэн үйлчилгээний тарифийн дээд, доод хязгаарын тухай)
56	Тогтоол 56	2013.09.20	Тусгай зөвшөөрөл олгох, хамрах хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
57	Тогтоол 57	2013.10.04	Зохицуулалт шинэчлэн батлах тухай

			(Интернэт харилцан холболтын үйлчилгээний зохицуулалт)
58	Тогтоол 58	2013.10.04	Тусгай зөвшөөрөл олгох тухай
59	Тогтоол 59	2013.10.25	Тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрлийн төрөл ба хамрах хүрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
60	Тогтоол 60	2013.12.06	Зохицуулалтын баримт бичиг батлах тухай (Тусгай дугаар ашигласан ярианы үйлчилгээний зохицуулалт)
61	Тогтоол 61	2013.12.06	Журам шинэчлэн батлах тухай (Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрлийг өрсөлдүүлэн шалгаруулж олгох журам)
62	Тогтоол 62	2013.12.06	Радио давтамжийн хуваарилалт батлах тухай (Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт ашиглах тоон телевизийн өргөн нэвтрүүлгийн радио давтамжийн хуваарилалт)
63	Тогтоол 63	2013.12.06	Тусгай зөвшөөрөл олгох, сэргээх, өөрчлөлт оруулах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай
64	Тогтоол 64	2013.12.20	Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг шинэчлэн батлах тухай ("Шуудангийн сүлжээ байгуулах, түүнийг ашиглах А-ангиллын тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага", "Шуудангийн үйлчилгээ эрхлэх Б-ангиллын тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага")
65	Тогтоол 65	2013.12.20	Хөрөнгийн хэмжээг тогтоох тухай (Шуудан: Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд 2014 онд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ)
66	Тогтоол 66	2013.12.20	Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулах тухай
67	Тогтоол 67	2013.12.20	Тусгай зөвшөөрөл олгох тухай
68	Тогтоол 68	2013.12.20	Уралдаант шалгаруулалт зохион байгуулах тухай
69	Тогтоол 69	2013.12.25	Тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох тухай
70	Тогтоол 70	2013.12.25	"Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
71	Тогтоол 71	2013.12.25	Хорооны хуралдааны дэг, Ёс зүйн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
72	Тогтоол 72	2013.12.25	Ажилд томилох тухай
73	Тогтоол 73	2013.12.25	Ажилд томилох тухай

Хоёр. Хорооны хуралдааны тэмдэглэл

1	Тэмдэглэл-1	2013.01.11	Нөхцөл, шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай (2013 оны 1 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлэх)
2	Тэмдэглэл-2	2013.01.11	Нөхцөл, шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай (Нэмэлт өөрчлөлтийг боловсруулан 2013 оны 1 дүгээр улиралд багтаан хуралдаанд танилцуулах)
3	Тэмдэглэл-1	2013.02.27	Санамж бичгийн тухай
4	Тэмдэглэл-1	2013.03.01	Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай (РДХЗА)
5	Тэмдэглэл-1	2013.05.01	АйПи телевизийн үйлчилгээний талаар авах арга хэмжээний тухай
6	Тэмдэглэл-2	2013.05.01	Юу-Би-Дэ-Эм-Би ХХК (UB DMB) ХХК-ийн талаар цаашид авах арга хэмжээний тухай
7	Тэмдэглэл-3	2013.05.01	Орхон аймагт хийсэн хяналт, шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай
8	Тэмдэглэл-4	2013.05.01	Төслийн талаар авах арга хэмжээний тухай
9	Тэмдэглэл-1	2013.09.06	АйПи телевизийн талаар авах зарим арга хэмжээний тухай
10	Тэмдэглэл-2	2013.09.06	Тусгай дугаар ашигласан ярианы үйлчилгээний зохицуулалт, орлого хуваарилах зарчмын талаар авах арга хэмжээний тухай
11	Тэмдэглэл-3	2013.09.06	Үүрэн холбооны давамгайл байддалтай үйлчилгээ эрхлэгчийн үнэ тарифийн талаар авах арга хэмжээний тухай

12	Тэмдэглэл-1	2013.09.20	Кабелийн сувгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай
13	Тэмдэглэл-2	2013.09.20	Хорооны шинэ бэлэг тэмдгийн /logo/ талаар авах арга хэмжээний тухай
14	Тэмдэглэл-1	2013.10.04	Тусгай зөвшөөрлийн талаар авах арга хэмжээний тухай
15	Тэмдэглэл-2	2013.10.04	Хүсэлтийн тухай танилцуулга /Мобиком ХХК/
16	Тэмдэглэл-3	2013.10.04	Хорооны даргаар ажиллаж байсн Л.Лантуу, Л.Баяраа нарын өргөдөл, хүсэлтийн тухай
17	Тэмдэглэл-1	2013.12.06	Тусгай дугаар ашигласан ярианы үйлчилгээний зохицуулалтыг хэрэгжүүлэх талаар зарим авах арга хэмжээний тухай
18	Тэмдэглэл-2	2013.12.06	Кабелийн сувгийн зөвшөөрлийн талаар танилцуулга, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах тухай
19	Тэмдэглэл-3	2013.12.06	ХХЗХ-д дотоод аудитын тогтолцоог нэвтрүүлэх талаар авах арга хэмжээний тухай
20	Тэмдэглэл-1	2013.12.25	Тусгай зөвшөөрлийн үйлчилгээ, байгууллагын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх зарим арга хэмжээний тухай
21	Тэмдэглэл-2	2013.12.25	“Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2014-2016 оны үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, стратеги” баримт бичгийг боловсруулах тухай

**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО
2013-12-31**